



ГЛОБАЛ УДИРДАГЧ ИХ СУРГУУЛЬ

МАГИСТРЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

*Дэлхийн боловсролыг
Монголдоо*



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ



Дэлхийн боловсролыг Монголдоо уриатай Глобал Удирдагч Их Сургууль нь Монгол улсаа уул уурхайд суурилсан эдийн засгаас мэдлэгт суурилсан эдийн засагт шилжүүлэх үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулах зорилгыг тавин ажиллаж байна. Үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн Монголын 4500 гаруй шилдэг оюутан залуучуудыг АНУ болон бусад өндөр хөгжилтэй орнуудад тэтгэлэгтэй сургаж, дээд боловсролын байгууллагуудаас Монголынхоо ирээдүйд 5 сая орчим долларын оюуны хөрөнгө оруулалтыг хийж чадсан цорын ганц сургууль билээ.

Өөрчлөгдөн хувьсаж буй өрсөлдөөний өнөө үед дэлхийн түвшинд хөрвөх чадвартай, үнэт зүйлтэй, ёс зүйтэй, хариуцлагатай, нийгэмдээ эерэг өөрчлөлтийг авчрах чадвартай ирээдүйн удирдагч нарыг төлөвшүүлэх нь 21-р зууны жинхэнэ боловсролын шаардлага, эрэлт хэрэгцээ болоод байна. Дэлхийн хэл болох Англи хэлийг эзэмшүүлж, Харвардын их сургуулийн хөтөлбөрийг Монголдоо анхлан нутагшуулж байгаагаараа Глобал Удирдагч Их Сургууль нь бусдаас ялгаатай.

Анагаах ухаан, Эдийн засаг, Сувилахуй, Хүмүүнлэгийн салбар сургуулиудаараа дамжуулан 20 гаруй мэргэжлээр сургалтын хөтөлбөрөө Харвард, Оксфордын сургалтын аргачлалаар шинэчлэн явуулах болсон нь Монголын дээд боловсролын шинэчлэлд оруулж буй бидний цоо шинэ хувьсгал юм. АНУ, Өмнөд Солонгос, Тайвань зэрэг өндөр хөгжилтэй орнуудад 2 дугаар курсээсээ шилжин суралцах хос дипломын 1+1 хөтөлбөрт дэлхийн 160 гаруй дээд сургуульд суралцах боломж таны өмнө нээлттэй байна.

Харвардын Их Сургуулийн жинхэнэ манлайлын хөтөлбөрийг Монголдоо анхлан нутагшуулж оюутан бүрийг хөгжүүлэх тусгай хөгжлийн хөтөлбөртэй болсоноор боловсролын чанар, үр дүнд эерэгээр нөлөөлж чадсан. Мэргэжлийн хичээлүүдийг Англи, Монгол хэлээр хослон зааж гадны зочин багш нар онлайн болон танхимын сургалтыг ордог нь дэлхийн боловсролыг дотоодын төлбөрөөр эзэмших боломжтой болж байна.

Манай бизнес болон боловсролын удирдлагын магистрын хөтөлбөрүүдийг сонгон суралцаж буй та бүхэндээ амжилт хүсье!

Хүндэтгэсэн:

Бархүүгийн Отгонбат
Удирдах зөвлөлийн дарга
Харвардын их сургуулийн төгсөгч
(МС/МРА 2016, Harvard University)

Монголынхоо хөгжлийн төлөө
хамтдаа зүтгэе!



Эрхэм зорилго

Мэдээллийн эрин зуунд дээд боловсролын зах зээлд **ЧАНАРЫН МАНЛАЙЛАГЧ СУРГУУЛЬ** болж дэлхийн жишигт нийцсэн, ур чадварт суурилсан хөтөлбөрөөр дамжуулан өндөр мэргэжил, ур чадвартай, хариуцлага, ёс зүйтэй үндэсний болон олон улсын түвшинд өрсөлдөх өндөр чадвартай манлайлагчдын шинэ үеийг бэлдэхэд оршино.

Алсын хараа

Монгол улсын дээд боловсролын зах зээлд чанар, үр дүнгээрээ манлайлагч судалгаан дээр суурилсан цогц их сургууль болон хөгжинө.


- Өндөр мэргэжил, ур чадвар, хариуцлага, ёс зүйтэй хүн төлөвшүүлнэ.
- Үндэсний болон Олон улсын түвшинд өрсөлдөх чадвар олгоно.
- Бизнес, эрүүл мэнд, англи хэлний мэргэжлийн манлайлагч бэлтгэнэ.

Үнэт зүйлс

- Сэтгэл, зүтгэл, зорилго нэгт **ЧАДВАРЛАГ БАГ**
- Сурах хүсэл, арга барилтай **ЧАДАВХИТАЙ ОЮУТАН**
- Дэлхийн түвшингийн **ЧАНАРТАЙ ХӨТӨЛБӨР**
- Гадаад, дотоодын хөдөлмөрийн зах зээлд **ЭРЭЛТ ИХТЭЙ ТӨГСӨГЧ**
- Ажиллаж байгаа газраа өөрчлөлт хөгжлийг чиглүүлэх **МАНЛАЙЛАГЧИД**

Манлайллын хөтөлбөр

Удирдагч хүн амжилтанд ганцаараа хүрдэггүй. Чөлөө завгүй байгууллага удирдаж яваа удирдагчдын хувьд ажлын ердийн орчноосоо гарч алдаа оноогоо бодох, засах, бусад удирдагчдаас туршлага судалж харилцан суралцах боломж ховор байдаг. LDG буюу манлайллын хөгжлийн багт оюутан бүр суралцах хугацаандаа оролцож Харвардын Их Сургуулийн жинхэнэ манлайллын болон зохицон манлайллын хөтөлбөрүүдийн дагуу долоо хоног бүрийн уулзалтаар дамжуулан суралцах боломж нээгдэнэ. Энэ сургалтын аргачлалаар дамжуулан оюутан бүр жинхэнэ манлайллын кэйс, дасгал, эргэцүүлэмжит эссэнүүдийн тусламжтайгаар хувь хүний хувьд чадваруудаа өсгөх ховорхон боломжийг олгож байгаа юм.



Хөтөлбөрийн алсын хараа

Монголдоо болон дэлхийн боловсролын салбарт эерэг өөрчлөлтийг авчрах манлайлагчдын шинэ үеийг бэлтгэхэд оршино.

Кэйс сургалт

Манай сургууль бүх хичээлээ Харвардын Их Сургуулийн кэйс сургалтын арга зүйн дагуу явуулж байна. Кэйс сургалт/тохиолдолд суурилсан/ нь онолын мэдлэгийг бодит амьдралтай холбож өгсөнөөр оюутанд практик ур чадвар сайтар эзэмшүүлдэг онцлогтой.

Тэтгэлэгт хөтөлбөр

Манай сургуулийн харьяа Тайваний боловсролын төвөөс жил бүр 300 гаруй тэтгэлэг зарладаг бөгөөд хэлний болон сургалтын амжилт гаргасан оюутан бүр төгсөөд магистр, докторын зэргээр үргэлжлүүлэн суралцах боломжтой. Өнгөрсөн хугацаанд манай сургуулиас 4500 гаруй шилдэг залуучууд АНУ, Өмнөд Солонгос, Тайваний их, дээд сургуулиудад 100% тэтгэлэгтэй суралцсан.

1+1 Хос дипломын хөтөлбөр

iMBA, EMBA, Боловсролын Удирдлагын магистрын хөтөлбөрүүд нь Глобал Удирдагч Их Сургуулийн хамтын ажиллагаатай АНУ, Өмнөд Солонгос, Тайваний шилдэг их сургуулиудад 1+1 хос дипломын хөтөлбөрт хамрагдах боломжтой. Нийт 30 кредитийнхээ 50%-ийг дүүцүүлснээр тухайн орондоо үргэлжлүүлэн суралцаад Глобал Удирдагч Их Сургууль болон тухайн суралцаж буй сургуулийнхаа дипломтой төгсөнө.

Оюутан солилцооны хөтөлбөр

Энэхүү хөтөлбөрөөр суралцаж буй оюутан Глобал Удирдагч Их Сургуулийн хамтын ажиллагаатай сургуулиудад 1 семестрын хугацаанд тэтгэлэгтэй суралцах боломжтой. Глобал Удирдагч Их Сургуульд төлбөрөө бүрэн төлөөд хамтын ажиллагаатай ихэнх сургуулиудад төлбөргүйгээр оюутан солилцоогоор суралцах боломжтой.

ЗАХИРЛУУДАД ЗОРИУЛСАН БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР (EMBA)

Бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөр нь Монголд нутагшуулсан Харвардын Их Сургуулийн хөтөлбөрөөр явагдах Монголын анхны хөтөлбөр бөгөөд жилд Монголын шилдэг 200 компани, төрийн болон төрийн бус байгууллагуудын удирдагч нарыг сургана.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Одоогийн байдалдаа нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, өсөлт өөрчлөлтийг манлайлах, ирээдүйн өөрчлөлтөө одооноос төлөвлөх мэдлэг, ур чадвар олгоно.

СУРГАЛТЫН АРГАЧЛАЛ

Глобал Удирдагч Их Сургуулийн энэхүү захирлуудын бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөр нь Харвардын Их Сургуулийн кэйс сургалтын аргачлал дээр суурилах бөгөөд онол практикийг хослуулсан гэдгээрээ бусдаас ялгаатай. Сургалтыг Англи, Монгол хэлээр хослон явуулна.

БИЗНЕС ТУР ХӨТӨЛБӨР

Сар бүр оролцогчдын компани эсвэл байгууллагуудаар зочилж, үйл ажиллагаатай танилцаж туршлага судлахаас гадна тус байгууллагын өмнө тулгарч байгаа бэрхшээлийг кэйс аргачлалаар анализ хийнэ.

ЗОЧИН ИЛТГЭГЧ ХӨТӨЛБӨР

Сар бүр бизнесийн салбарын манлайлагч захирлуудыг урьж, нээлттэй ярилцлагыг “**GLU CEO FORUM**” - аар дамжуулан зохион байгуулна.



ГАДААД АЯЛАЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

Энэхүү хөтөлбөрийн оролцогч бүр гадаад аялал сургалтанд заавал хамрагдах шаардлагатай. Харвардын Их Сургууль болон Тайваний Үндэсний Чин-И Технологийн Их Сургуулиудад зуны богино хугацааны аялал хийх, сургалтанд хамрагдах, хөрөнгө оруулалтын хамтрагч олох зэрэг хөтөлбөрүүдэд хамрагдана. Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын сургалтанд хамрагдаж гадаад зах зээлд гарах, олон улсын зах зээлээс хөрөнгө босгох, төслөө хэрхэн бичих зэрэг сургалтуудыг явуулна.

Нийт 30 кредит үнэлгээний хичээлүүдийг 3 модулын түвшинд хувааж 1.5 жилийн хугацаанд судална.

1. Одоогийн байгаа нөхцөл байдалдаа дүн шинжилгээ хийх түвшин

Үзэх хичээлүүд

- Санхүүгийн менежмент (3 кредит)
- Санхүүгийн хяналт, шинжилгээ (3 кредит)
- Эрсдлийн менежмент (3 кредит)

2. Өсөлт ба өөрчлөлтийг манлайлах түвшин

Үзэх хичээлүүд

- Жинхэнэ манлайлал (3 кредит)
- Байгууллагын зан төлөв (3 кредит)
- Төслийн менежмент (3 кредит)
- Харилцааны урлаг (3 кредит)
- Маркетингийн менежмент (3 кредит)
- Үйл ажиллагаа ба технологийн менежмент (3 кредит)
- Хүнийн нөөцийн менежмент (3 кредит)
- Компанийн засаглал (3 кредит)

3. Ирээдүйн шилжилтийг одооноос төлөвлөх түвшин

Үзэх хичээлүүд

- Стратегийн менежмент (3 кредит)
- Борлуулалт (3 кредит)
- Гүйцэтгэлийн менежмент (3 кредит)
- Хөрөнгө оруулалт (3 кредит)

НИЙТ 30 КРЕДИТ

БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР (iMBA)

Ирээдүйн захирлуудад зориулсан бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөр нь Харвардын Их Сургуулийн Монголд нутагшуулсан хөтөлбөрөөр явагдах Монголын анхны бөгөөд цорын ганц хөтөлбөр юм. Бид жилд Монголын шилдэг 200 компани, төрийн болон төрийн бус байгууллагуудын ирээдүйн удирдагч нарыг сургана.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Суралцагчдад бизнесийн удирдлагын суурь ур чадвар эзэмшүүлэх, бизнесийн байгууллагын удирдах олон талт ур чадварыг бий болгож хөгжүүлэх, өөрчлөлтийг манлайлах, мэдлэг, ур чадвар, дадал олгох явдал юм.



ГЛОБАЛ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Глобал Удирдагч Их Сургуулийн оюутан болсноор хамтын ажиллагаатай гадаадын их, дээд сургуулиудад дараах 3 төрлийн тэтгэлэгээр суралцах боломж нээгдэнэ.

- А: Сургалтын төлбөрийн 100% тэтгэлэг + 200 ам долларын стипенд + оюутны дотуур байрны тэтгэлэг
- В: Сургалтын төлбөрийн 100% тэтгэлэг
- С: Сургалтын төлбөрийн 50% тэтгэлэг

Жич: Англи хэлний шалгалтын оноо шаардлагатай.

БИЗНЕС ТҮР ХӨТӨЛБӨР

Сар бүр оролцогчдын компани эсвэл байгууллагаар зочилж, үйл ажиллагаатай танилцаж туршлага судлахаас гадна тус байгууллагын өмнө тулгарч байгаа бэрхшээлийг кейс аргачлалаар анализ хийнэ.

АНГЛИ, СОЛОНГОС, ХЯТАД ХЭЛНИЙ ЭРЧИМЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР

Хэрэв ГУИС-ийн хамтын ажиллагаатай сургуулиудад семестр солилцооны болон 1+1 хос дипломын хөтөлбөрт оролцохоор сонгосон тохиолдолд нэмэлт төлбөргүйгээр 2 кредитийн гадаад хэлний эрчимжүүлсэн хөтөлбөрт ажлын бус цагаар хамрагдана. TOEFL, IELTS, TORIK, HSK шалгалтуудад бэлдэнэ.

ЗОЧИН ИЛТГЭГЧ ХӨТӨЛБӨР

Сар бүр бизнесийн салбарын манлайлагч захиралуудыг урьж нээлттэй ярилцлагыг “GLU CEO Forum” аар дамжуулан зохион байгуулна.

СУРГАЛТЫН АРГАЧЛАЛ

Глобал Удирдагч Их Сургуулийн энэхүү ирээдүйн захирлуудын бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөр нь Харвардын Их Сургуулийн кэйс сургалтын аргачлал дээр суурилах бөгөөд онол практикийг хослуулсан хөтөлбөр гэдгээрээ бусдаас ялгаатай. Сургалтыг Англи, Монгол хэлээр хослуулан явуулна.

iMBA хөтөлбөрт үзэх 36 кредитийн хичээлүүдийг 1.5 жилийн хугацаанд судална.

1. Бизнесийн суурь чадвар хөгжүүлэх түвшин

- Санхүүгийн менежмент (3 кредит)
- Санхүүгийн хяналт, шинжилгээ (3 кредит)
- Эрсдлийн менежмент (3 кредит)
- Энтрэпрэнэршип (3 кредит)

2. Бизнесийн олон талт чадвар хөгжүүлэх түвшин

- Жинхэнэ манлайлал (3 кредит)
- Байгууллагын зан төлөв (3 кредит)
- Гүйцэтгэлийн менежмент (3 кредит)
- Харилцааны урлаг (3 кредит)
- Маркетингийн менежмент (3 кредит)
- Үйл ажиллагаа ба технологийн менежмент (3 кредит)
- Хүний нөөцийн менежмент (3 кредит)
- Англи хэл (2 кредит)

3. Өөрчлөлтийг манлайлах түвшин

- Олон улсын бизнес (3 кредит)
- Стратегийн менежмент (3 кредит)
- Борлуулалтын менежмент (3 кредит)

Үлдсэн 6 кредитийн шаардлагыг дараах 3 сонголтоос аль нэгийг сонгох ёстой

- Магистрын диплом бичих, мэргэжлийн хичээл (6 кредит)
- Нэмэлт хичээл (6 кредит)
- ГУИС-ийн хамтын ажиллагаатай гадаадын их сургуулийн солилцооны хөтөлбөрт хамрагдах (6 кредит)

Нийт 36 кредит

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГЫН МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР (MASTER OF EDUCATION LEADERSHIP)

БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Монгол улсад мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгож хөгжүүлэхэд боловсролын салбарын шинэчлэл, өөрчлөлт нэн чухал болоод байна. Монгол улсын 21 аймаг, 9 дүүргийн ЕБС-ийн 100,000 гаруй багшийг хөгжүүлэх, чадавхижуулах, дэлхийн боловсролтой хөл нийлүүлэн алхуулахад багшийн хөгжил нэн тэргүүнд тавигдах ёстой. Тиймээс ГУИС-аас санаачлан боловсролын удирдлагын магистрын хөтөлбөртөө тэтгэлэг зарлаж байна. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь багшийг хөгжүүлэхэд, ирээдүй хойч үедээ чанартай боловсрол олгоход багш хүний үнэ цэнийг өсгөхөд оршино.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Дэлхийн түвшний хөтөлбөр, шилдэг багш нар, кэйс сургалтын аргачлал, Харвардын манлайлын хөтөлбөр, гадаад оюутан солилцоо, хос дипломын хөтөлбөрүүд, судлаач багшийг бэлдэх хөтөлбөр зэрэг олон талт онол, практик хосолсон аргачлалаар ирээдүйн боловсролын салбарт манлайлах багш нарыг бэлдэхэд оршино.

ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР (1.5 ЖИЛ, 30 КРЕДИТ)

БОЛОМЖИТ МЭРГЭШИХ ЧИГЛЭЛҮҮД:

- Сургуулийн өмнөх боловсрол
- Бага ангийн багшийн боловсрол
- Боловсролын бодлого, менежмент
- Боловсролын манлайлал
- Дээд боловсрол
- Хүний хөгжил ба сэтгэл судлал
- Хэл уран зохиол
- Суралцахуй ба багшлахуй
- Сургуулийн манлайлал
- Багшийн боловсрол
- Технологи, инноваци ба боловсрол
- Бусад

ДАВУУ ТАЛУУД

- Харвардын жинхэнэ манлайлын хөгжлийн хөтөлбөр
- Сургалтын төлбөрийн 1 сая төгрөгийн тэтгэлэг
- Дэлхийн 160 гаруй шилдэг их сургуулиудад тэтгэлэгтэй суралцах боломж
- Оюутан солилцоо, хос дипломын 1+1 хөтөлбөрөөр шилжин суралцаж дэлхийд гарах боломж
- Англи, Солонгос, Хятад хэлний үнэгүй, эрчимжүүлсэн бэлтгэл хөтөлбөр
- Харвардын кэйс сургалтын аргачлал
- Онлайн сургалтын технологи
- Инноваци, гарааны компанийн хөтөлбөр
- Зочин илтгэгчдийн хөтөлбөр
- Нэр хүндтэй боловсролын байгууллагуудад болон төрийн ба төрийн бус байгуудлагуудад дадлага хийх боломж
- Ажлын байрандаа өөрийгөө хөгжүүлэх карьер ахих боломж
- Хүчтэй төгсөгчдийн холбоо, насан туршдаа суралцах боломж

Боловсролын Удирдлагын магистрын хөтөлбөрт үзэх 30 кредитийн хичээлүүдийг 1.5 жилийн хугацаанд судална.

1. Мэргэжлийн суурь хичээл	<ul style="list-style-type: none"> • Англи хэл (2 кредит) • Жинхэнэ манлайлал (3 кредит) • Судалгааны арга зүй (4 кредит) • Хүний нөөцийн менежмент (3 кредит)
2. Мэргэшүүлэх заавал судлах хичээл	<ul style="list-style-type: none"> • Боловсролын үнэлгээ (3 кредит) • Боловсролын менежмент (3 кредит) • Боловсролын бодлогын анализ (3 кредит) • Хөтөлбөрийн манлайлал (3 кредит)
3. Мэргэшүүлэх сонгон судлах хичээл	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөр, төслийн удирдлага (3 кредит) • Харилцааны ур чадвар (3 кредит) • Байгууллагын зан төлөв (3 кредит) • Тогтвортой хөгжлийн боловсрол (3 кредит)
4. Судалгааны ажил	<ul style="list-style-type: none"> • Судалгааны, онолын семинар (3 кредит) • Судалгааны ажил (5 кредит)

НИЙТ 30 КРЕДИТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО, УДИРДЛАГА (MASTER OF MEDICAL LEADERSHIP)

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Глобал Удирдагч дээд сургууль нь анагаах, сувилахуйн чиглэлийн бакалаврын сургалтуудыг амжилттай зохион байгуулж ирсэн туршилга дээр тулгуурлан эрүүл мэндийн удирдлагын чиглэлээр ахисан түвшний сургалтыг орчин үеийн кейс сургалтын хөтөлбөрөөр XXI -р зууны чадвар чадамжийг олгон, манлайлагч байх, шинийг санаачлагч байх, харилцааны өндөр ур чадвартай ирээдүйн эрүүл мэндийн салбарт ихийг хийж бүтээх чин хүсэлтэй боловсон хүчинг бэлтгэнэ. ГУДС-ийн ахисан түвшинд суралцаж буй оюутнуудаараа дамжуулан инновацийг нэвтрүүлж, мэргэшсэн салбартаа эзэн болж эрүүл мэндийн салбарт шинэчлэлийг авч ирэх залуу судлаачдыг бэлдхэд оршино.



ДАВУУ ТАЛУУД

Глобал Удирдагч Дээд сургуулийн “Эрүүл мэндийн бодлого, удирдлага” -ын магистрын хөтөлбөрт суралцаж төгссөн төгсөгчид нь эрүүл мэндийн удирдлагын 25 багц, 205 төрлийн мэдлэг, хандлага, ур чадварыг эзэмшиж төгсөнө.



ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР (1.5 ЖИЛ, 30 КРЕДИТ)

Боловсролын Удирдлагын магистрын хөтөлбөрт үзэх 30 кредитийн хичээлүүдийг 1.5 жилийн хугацаанд судална.

1. Мэргэжлийн суурь хичээл	<ul style="list-style-type: none"> • Англи хэл (2 кредит) • Жинхэнэ манлайлал (3 кредит) • Судалгааны арга зүй (4 кредит) • Хүний нөөцийн менежмент (3 кредит)
2. Мэргэшүүлэх заавал судлах хичээл	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн тогтолцоо, бодлого, хөтөлбөр (2 кредит) • Эрүүл мэндийн эдийн засаг, санхүүжилт (2 кредит) • Эрүүл мэндийн удирдлага, менежмент (2 кредит) • Нийгмийн эрүүл мэндийн удирдлага (2 кредит) • ЭМ-ийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлын удирдлага (2 кредит) • ЭМ-ийн статистик, мэдээллийн удирдлага (2 кредит)
3. Мэргэшүүлэх сонгон судлах хичээл	<ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн ажилтны ёс зүй, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж (3 кредит) • ЭМ-ийн ажилтны нийгмийн баталгаа (3 кредит) • Байгууллагын зан төлөв (3 кредит) • Харилцааны ур чадвар (3 кредит)
4. Судалгааны ажил	<ul style="list-style-type: none"> • Судалгааны, онолын семинар (3 кредит) • Судалгааны ажил (5 кредит)

НИЙТ 30 КРЕДИТ

БАКАЛАВРЫН ОРОЙ ЭЧНЭЭ ХӨТӨЛБӨРҮҮД

Бакалаврын орой эчнээ хөтөлбөрүүд

Хөтөлбөрүүд	Хэлбэр	Суралцах хугацаа
Нягтлан бодох бүртгэл	<ul style="list-style-type: none"> • Орой • Эчнээ 	<ul style="list-style-type: none"> • 2.5 жил • 3.5 жил
Санхүү	<ul style="list-style-type: none"> • Орой 	<ul style="list-style-type: none"> • 2,5 жил
Банк	<ul style="list-style-type: none"> • Орой 	<ul style="list-style-type: none"> • 2,5 жил
Менежмент	<ul style="list-style-type: none"> • Орой • Эчнээ 	<ul style="list-style-type: none"> • 2.5 жил • 3.5 жил
Багш, гадаад хэлний боловсрол	<ul style="list-style-type: none"> • Орой 	<ul style="list-style-type: none"> • 2.5 жил
Багш, нийгмийн ухааны боловсрол	<ul style="list-style-type: none"> • Орой 	<ul style="list-style-type: none"> • 4 - 5 жил
Багш, Монгол хэл-уран зохиолын боловсрол	<ul style="list-style-type: none"> • Орой 	<ul style="list-style-type: none"> • 4 - 5 жил
Сэтгүүл зүй	<ul style="list-style-type: none"> • Орой • Эчнээ 	<ul style="list-style-type: none"> • 4-5 жил • 2.5 - 3.5 жил

БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Манай сургуулийн багш нар Харвард, Манчестр, Тафс, Брэндайз зэрэг дэлхийн шилдэг сургуулиудыг магистр, докторын зэргээр суралцан төгсч бизнесийн байгууллагад ажиллаж байсан олон жилийн туршлагатай Монгол, гадаад багш нарын бүрэлдэхүүнтэй. Зарим хичээлүүдийг зочин багш хүрэлцэн ирж заахаас гадна онлайн хэлбэрийн хичээл, хэлэлцүүлэг, NEO онлайн флатпормоор дамжуулан заах боломжтой.



**Бархүүгийн
Отгонбат**

Б.Отгонбат нь Глобал Удирдагч Их Сургуулийн Удирдах зөвлөлийн дарга бөгөөд захирлуудын магистрын хөтөлбөрийн санаачлагч юм. Тэрээр АНУ-ын Дикинсоны улсын их сургуулийг бизнесийн удирдлагын чиглэлээр бакалавр, Австралийн Кюнсландын их сургуулийг аялал жуулчлалын магистр, 2016 онд Харвардын их сургуулийн Жон Ф.Кэннедигийн нэрэмжит төрийн удирдлагын магистр зэргээр тус тус төгссөн. Сүүлийн 10 гаруй жил бизнесийн салбарт ажиллаж манлайлал, стратеги, байгууллагын хөгжлийн сэдвээр сургалт лекцүүдийг амжилттай зохион байгуулж ирсэн. Америкт болон тайваньд суралцах боломж бэстсэллэр номнуудын зохиогч бөгөөд “Глобал СИӨ”, “Глобал Удирдагч” телевизийн төслүүдийг санаачлан ажилласан. Харвардын жинхэнэ манлайлын хөтөлбөрийг Монголдоо нутагшуулж уг хөтөлбөрийг анхлан магистрын түвшний хөгжлийн хөтөлбөр болгон хөгжүүлэн ажиллаж байна.



**Дэйна
Борн**

Дэйна Борн нь Харвардын Их Сургуулийн профессор бөгөөд Глобал Удирдагч Их Сургуулийн удирдах зөвлөлийн гишүүн юм. Хадагтай Борн нь АНУ-ын агаарын хүчний албанд бригадын генерал хүртлээ дэвшсэн анхны эмэгтэй бөгөөд агаарын хүчний академид байгууллагын зан төлөв, манлайлын албаны даргаар Харвардад ирэхээсээ өмнө ажиллаж байсан. Дэйна Борн нь туршилтын болон судалгааны сэтгэл зүйгээр хос магистрын зэргийг Тринити болон Мэлбурны их сургуулиудад хамгаалсан. Байгууллагын сэтгэл зүйн чиглэлээр Пэнсэлвайн мужын их сургуульд докторын зэрэг хамгаалсан. Харвардын Их Сургуульд жинхэнэ манлайлын хичээл заадаг бөгөөд Глобал Удирдагч Их Сургуулийн магистрын хөтөлбөрт зориулж тус хичээлийн багш, зөвлөхөөр ажиллана. Дэлгэрэнгүй намтарыг: www.hks.harvard.edu/about/data-born линкээс авах боломжтой.



Нацагийн Удвал

Н.Удвал нь Глобал Удирдагч Их Сургуулийн эрдмийн зөвлөлийн даргаар ажилладаг. Монгол Улсын Засгийн Газрын гишүүн, Эрүүл Мэндийн сайд, дэд сайдаар ажиллаж байсан. Тэрээр МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн анхны эмэгтэй нэр дэвшигч юм. Тэрээр английн Манчестрын их сургуулийг Эрүүл мэндийн удирдлагаар магистр, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор зэрэгтэй. Тус хөтөлбөрт нөхцөл байдлын шинжилгээ, Бизнес ба төр хичээлүүдийг тус тус ордог.



Даваасүрэнгийн Мөнхжаргал

Д.Мөнхжаргал нь Глобал Удирдагч Их Сургуулийн удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд боловсролын салбарын манлайлагчдын нэг юм. АНУ-ын Ваяомир мужын их сургуулийг боловсролын хөтөлбөр судлалаар докторын зэрэг хамгаалсан, Японы Айчи их сургуулийг хөтөлбөр, заах арга зүйгээр магистрын зэргээр төгссөн. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн захирлаар ажиллаж байсан туршлагатай зэрэг судлаач, багш, боловсролын салбарын манлайлагч юм. Манай Боловсролын Удирдлагын магистрын хөтөлбөрт сургалтын хөтөлбөрийн манлайлал гэсэн хичээлийг заахаас гадна хөтөлбөрийн удирдагчаар ажиллана.



Гэндэнгийн Тэгшбүрэн

Г.Тэгшбүрэн нь Монгол Улсын Их Сургуулийн Инженер Механикийн Их Сургуулийг Инженер Механикийн чиглэлээр бакалавр, Удирдлагын Хөгжлийн Институтэд Удирдахуйн ухааны магистр, Энэтхэгийн Делид Хүний Нөөцийн Удирдлагаар магистр, докторантурт суралцаж төгссөн. 2010 онд Энэтхэгийн Ранчигийн Их Сургуулийн Синха Институтийн хүндэт Профессор цол хүртсэн.



Рэгсүрэнгийн Бат-Эрдэнэ

Р.Бат-Эрдэнэ нь нь АНУ-ын Питбургийн их сургуулийг боловсролын удирдлагаар доктор зэрэгтэй төгссөн. Монгол Улсын Их Сургуулийн захирал, БСШУЯ-ны төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга зэрэг хариуцлагатай ажилуудыг хийж байсан. Манай хөтөлбөрт боловсролын удирдлага, бодлого зэрэг хичээлүүдийг орно.



Сүхбаатарын Эрдэнэболд

С.Эрдэнэболд нь харилцааны урлагын чиглэлээр олон ном зохиол бичиж нийтлүүлсэн багш бөгөөд АНУ - ын Индианагын их сургуулийг хуулийн чиглэлээр, Харвардын Их Сургуулийг нийтийн удирдлагын чиглэлээр тус тус магистрын зэргээр төгссөн. Энэхүү хөтөлбөрт харилцааны урлаг, олон нийттэй харилцах чиглэлээр хичээл заана.



Лувсандоржийн Оюун

Л.Оюун нь 1973 - 1978 онд ОХУ-ын Санкт-Петербургийн их сургуулийг Эдийн Засгийн бакалавр, магистр, 1989 Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн ухааны доктор, профессор. Тус хөтөлбөрт санхүү удирдлага, судалгааны арга зүй хичээлүүдийг тус тус ордог.



Галнэмэхийн Цогнэмэх

Г.Цогнэмэх нь Монгол Улсын Техникийн их сургуулийг Бизнесийн Удирдлагын бакалавр, тус сургуулийг Олон Улсын Бизнесийн Удирдлагын магистр, Испани Улсын Мадрид хотын Instituto De Empresa Бизнес сургуулийн Олон Улсын Бизнесийн Удирдлагын магистрын зэргээр тус тус төгссөн. Г.Цогнэмэх нь 2016 оноос өнөөг хүртэл “Монцемент Билдинг Материалс” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, 2015-2016 онд “Грийн Сити” ХХК-ийн Борлуулалт хариуцсан захирлаар, 2007-2010 онд “М-Си-Эс Дистрибушин” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.



Содномдоржийн Санасэр

С.Санасэр нь 2002 онд МУИС, Эдийн засгийн сургуулийг Эдийн засагч, Бизнесийн Удирдлага мэргэжлээр төгссөн. Калифорнийн ОУ-ын их сургуульд ОУ-ын Бизнесийн магистр. Компаний засаглалын судалгаагаар МУИС-ийн Бизнесийн сургуулийн докторант. Юта Валлэй их сургууль ОУ-ын санхүүгийн корпарацци, Америкийн ОУ-ын хөгжлийн ассоциаци, Удирдлагын академи, АНУ-ын IRI байгууллагын хамтарсан хөтөлбөрүүдэд мэргэжил дээшлүүлсэн. МҮОНРТ-ийн үндэсний зөвлөлийн гишүүн. Энэхүү хөтөлбөрт компаний засаглал, хөдөлмөрийн эдийн засаг, бизнесийн менежмент зэрэг хичээлүүдийг ордог.



Цэнгэмаагийн Амраа

Ц.Амраа нь ОХУ-ын Санкт-Петербургийн их сургуулийг харилцаа холбооны бакалавр, АНУ-ын Киллерийн Менежментийн их сургуулийг Бизнесийн Удирдлагын магистраар тус тус төгссөн. Ц.Амраа нь 2009-2016 онд Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газрын дэд дарга, 2005-2008 онд Юнител группийн гүйцэтгэх захирлаар, 1999-2003 онд Скайтел компаний Худалдааны хэлтсийн захирлаар, тус тус ажиллаж байсан. Одоо “Wellcom Petroleum” компаний Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Маркетингийн чиглэлээр сургалт, зөвлөгөө явуулдаг. Энэхүү хөтөлбөрт маркетингийн менежментийн хичээл заана.



Сэсили Тайлор

Хадагтай Тэйлор нь АНУ-ын Fortune 500 компаниудад маркетингийн зөвлөгөө өгдөг, телевизийн дижитал контентийн продюсер эмэгтэй юм. Түүх дээр суурилсан маркетингийн аргачлалаараа олон видео бүтээж шагнал урамшуулал удаа дараа хүртсэн. АНУ-ын NBC телевизээр бүтээл нь сайшаагдсан, энтрепэрнэр, зохиолч, боловсролын зүтгэлтэн юм. Сара Лоурэнс коллежийг урлагын менежментээр, Харвардын их сургуулийн магистрын зэргээр төгссөн. Одоо Харвардын их сургуульд зочин багшаар ажилладаг. Энэхүү хөтөлбөрт маркетинг, брэндийн хөгжил, дижитал контент, социал энтрепэрнэршип чиглэлээр хичээл заана.



Марк Сломиани

Марк нь Өмнөд Каролайна мужын анагаахын их сургуулийн эрдэмтэн, профессор бөгөөд төр хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалтын сан, инноваци, био-анагаахын салбарт хөрөнгө оруулсан энтрепэрнэр хүн юм. Радгэрс их сургуулийг бизнесийн удирдлагын магистр, Өмнөд Каролайнагийн их сургуулийг докторын зэргээр төгссөн. Энэхүү хөтөлбөрт хөрөнгө оруулалтын сан, төр хувийн хэвшлийн түншлэлийн чиглэлээр хичээл заана.



Рандал Трани

Р.Трани нь байгууллагын удирдлагуудад манлайлал, Харилцааны урлаг, нөлөөлөл, хувь хүний хөгжлийн сэдвээр дэлхий даяар сургалт хийсэн сургагч багш бөгөөд АНУ-ын улс төрч, алдарт зохиолч Аннэт Симмонсийн хувийн зөвлөхөөр амжилттай ажилласан. Харилцааны урлагын чиглэлээр нэр хүнд бүхий сонин, сэтгүүлүүдэд нийтлэл бичдэг. Колорадо мужын Техникийн их сургуулийг бизнесийн удирдлагын магистр, Харвардын Их Сургуулийг нийтийн удирдлагын магистраар тус тус төгссөн. Уг хөтөлбөрт харилцааны урлаг, манлайлал, Хувь хүний хөгжлийн сэдвээр хичээл заана.



**ЮНДЭНДОРЖИЙН
ХОРЛОО**

Ю.Хорлоо нь 2000 онд Улсын багшийн их сургуулийн “Биологи-Байгаль шинжлэлийн багш”, 2002 онд Улсын багшийн их сургуулийн “Хүний экологийн зарим асуудлууд”, 2013 онд бүгднайрамдах Солонгос улсын СунЧоны үндэсний их сургуулийг биологийн ухааны чиглэлээр “Characterization of Petroleum Oil and Endosulfan Degrading Bacteria from Marine Bacterial Libraries” тус тус зэрэг хамгаалсан. 2000-2008 онд ХААИС, Биологийн тэнхимийн багш, 2008-2013 онд БНСУ, СунЧоны үндэний их сургуульд Докторанд, судлаач, 2014-2015 онд ХААИС, АЭС, Сургалтын албанд санхүү эрхэлсэн орлогч захирал, 2016 оноос хойш ХААИС, АЭС, Экологийн тэнхимийн эрхлэгчээр тус тус ажиллаж байна.



**William
Lindau**

William Lindau нь 1983 онд АНУ-ын Appalachian State University сургуулийг физикийн мэргэжлээр бакалавр, 1994 онд сэтгэл судлалаар магистрын зэрэг хамгаалсан. АНУ-ын Хойд Каролайна мужийн ахлах сургуульд багшаар 1986-1990, Тэннесси Мужид Сэтгэл зүйчээр 1993-1995 онд тус тус ажиллаж байсан. Англи хэлний мэргэшсэн Tesol зэрэгтэй.



**Ганбүргэдийн
Солонго**


Г.Солонго нь АНУ-ын Висконсин мужын Hamilton High ахлах сургуулийг төгссөн. Virginia мужын Maryland Их Сургуулийг Бизнесийн Удирдлага чиглэлээр бакалаврын зэрэг, Глобал Удирдагч Их Сургуульд Бизнесийн удирдлагын магистрын зэрэг, Боловсролын Их Сургуулийн Боловсролын Удирдлагын докторант. Глобал Удирдагч Их Сургуулийн Хүмүүнлэгийн салбар сургуулийн захирал. Англи хэлний мэргэшсэн Tesol зэрэгтэй. Тус хөтөлбөрт мэргэжлийн болон харилцааны англи хэлний хичээлүүдийг тус тус ордог.




**Bryan Kimball
Smith**

Bryan Kimball Smith нь АНУ-ын Аризона мужын Phoenix их сургуульд байгууллагын менежментийн бакалаврын зэрэг, Бизнесийн удирдлагын магистрын зэрэг тус тус хамгаалсан. Leidos холбоонд багш, сургалт хөгжүүлэгчээр 2009-2018 онд, АНУ-ын Армид цагдаагийн ахлах түрүүчээр 1986-2017 онд ажиллаж байсан. Англи хэлний мэргэшсэн Tesol зэрэгтэй.

ХАРИЛЦАГЧ СУРГУУЛИУД



АМЕРИКИЙН
НЭГДСЭН УЛС



ТАЙВАНЬ



СОЛОНГОС
УЛС



МАГИСТРЫН АЛБА

Элсэлт хариуцсан захирал: 9901-7386

Магистрын албаны дарга: 9984-6867

Магистрын албаны менежер: 9901-1662, 8810-2956

Онлайн бүртгэл: glu.edu.mn/admin/app/registration.php

Веб сайт: www.glu.edu.mn

Facebook: [/GlobalLeadershipUniversity/](https://www.facebook.com/GlobalLeadershipUniversity/)